

Хотын Хүн эмнэлгийн байгууллага

1939-4-18-нд улсын бага хурлын тэргүүлэгчдийн газрын дэргэд Улаан хэрээстийн төвийн гүйцэтгэх хороог түр байгуулжээ.

1924 оны 8 дугаар сард хог буртаг, цэвэрлэх, ариун цэврийг сахих тусгай дүрэм гаргажээ.

1925-10-1-нд эрүүлийг хамгаалах төлөөлөгчийн газрыг байгуулж, мөн оны 10 дугаар сарын 20-нд Улаанбаатар хотод зөвлөлтийн боловсон эмч бүхий эмнэлгийн газар байгуулсан

1930-12-19-нд Засгийн газрын 42 дугаар хурлын 3 дугаар зүйлээр 1930 онд хотын амбулаторийг өргөтгөн өдөр тутамд 1000-1200 хүнд үйлчлэх чадалтай болгосон. Сестрагийн сургуулийг 100 хүртлэх хүнээр өргөтгөн байгуулсан гэж дурдаад Улаанбаатар хотын больницын орны тоог 275, мэдрэл, бактерийн больницын орыг 75 болгон өргөтгөхөөр заажээ.

1926 онд нийслэл хотод сестрагийн 6 сарын курс, 55 хүнтэй шинээр нээгдэж, энэ нь 1931 онд хүн эмнэлгийн техникум болсон байна.

1931 онд нийслэл хотод төв больниц төв амбулаториос гадна хий судлалын больниц арьс, өнгөний өвчний диспансер, шүдний эмнэлэг, ариун цэврийн лаборатори, сурагчдын амбулатори болон архины завод, аж үйлдвэрийн комбинат, монгол транс, туйпууны завод, төмрийн завод, хэвлэлийн хороо зэрэг гол үйлдвэр зарим том албан газрыг түшиглэн 10 шахам эмнэлэгийн салбар газрууд бий болжээ.

1931 онд ариун цэврийн дүрмийг баталжээ. Мөн хотын захиргааны дэргэд ариун цэврийн товчоо байгуулсан.

1932 онд Улаанбаатар хотод хүүхдийн ясли нээгдсэн бөгөөд 1932 онд түүний ор хоног 2916 байсан бол 1940 онд 9347 болжээ. Современная монголия 1941 он № 2-3

1934- онд Улаанбаатар хотод урьдчилан сэргийлэх тарилга 25617 хүнд хийсэн нь хотын хүн амын 65% -ийг хамарсан.

1934 онд Улаанбаатар хотын эх, нялхасыг хамгаалах газрын нэг нь 2 хүртлэх насны хүүхдийг бойжуулах асрах тасаг 2-3, Насны хүүхдийн тасаг, хүүхдийн сүү, хоол тэжээл боловсруулах газар, жирэмсэн эмэгтэйчүүдийг хэвтүүлэн хөнгөрүүлэх тасаг, хүүхэд/ эхчүүдэд зөвлөлгөө өгөх тасаг 2 байжээ. Мөн газар 49 ортой байсан байна.

1930 онд хотын больниц 130 ортой , мэс засал, нүд, дотор, халдварт, чих, хамар, хоолой, эмэгтэйчүүд, мэдрэл зэрэг 10 тасаг байсан бол 1935 онд 41 тасагтай, 406 ортой том эмнэлгийн газар болсон гэжээ

1935-2-8-нд Сайд нарын Зөвлөлийн 8 дугаар хурлын 5 дугаар зүйлээр Улаанбаатар хотод элдэв халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх больниц байгуулахыг Эрүүлийг хамгаалах яаманд даалгажээ.

1935 онд түргэн тусламжийн үйлчлэх хүрээ өргөжиж, хоногт үйлчлэх дуудлагын тоо 25 болж, "ГАЗ-АА" гэдэг машинаар үйлчлэх болов.

1938 онд Улаанбаатар хотын захирах яамны дэргэд ардын эмнэлгийн хэлтэс байгуулж, хотын доторхи эмнэлэг, ариун цэвэр, хүүхдийн цэцэрлэг, сувилалыг харьяалан удирдуулах болгож мөн хэлтсийн дүрмийг баталжээ.

1938-7-24-нд Ардын Сайд нарын Зөвлөлийн ерөнхий сайдын 155 дугаар тушаалаар эм бэлтгэлийн газрын түвд эмийн аптекийг татан буулгаж, түвд эмийн зүйлийг зарж борлуулахаар тогтоожээ.

1939-2-18 нд Сайд нарын Зөвлөлийн 4 дүгээр хурлын 6 дугаар зүйлээр улсын бага хурлын дэргэд байгуулагдсан Улаан хэрээстийн эвлэлийн хорооны түр дагаж явах дүрмийг батлахад уг дүрмэнд дорд байгууллага нь аймаг, хот, яамнад харьяалагдсан захиргааны удирдлагаар ажиллах үндсэн үүрийн даргаас эхлэн төвийн гүйцэтгэх хорооны тэргүүлэгчид хүртэл цөм сонгуулиар гүйцэтгэнэ гэжээ.

Үүнээс үзэхэд хотын Улаан загалмайн байгууллага энэ үеэс бий болсон байж болох байна.

Улаанбаатар хотод их, бага эмчийн салбар 1935 онд 9, 1939 онд 30 байжээ. Улаанбаатар хотын төв сувилалд эмчлүүлэхээр ирсэн хүмүүсийн тоо бүгд 1936 онд 53618, 1939 онд 217523 байлаа.

1940 онд Улаанбаатар хотод төв больниц, мэдрэлийн больницоос гадна 4 поликлиник, хүүхдийн амбулатори 2, эмэгтэйчүүдэд зөвлөлгөө өгөх газар 2, хүүхдийн зөвлөлгөө өгөх газар 1, арьс өнгөний диспансер, уушгины тасаг бий болсны дээр биеэ даасан түргэн тусламжийн газар 1, салбар 1 бий болжээ.

Комбинатын харьяа 7 эмчтэй поликлиник, Налайхад 3 эмч 10 ортой салбар байгуулсан бөгөөд хотынбусад үйлдвэр албан газруудад 19 бага эмчийн салбартай болжээ.

1941-10-3-нд Сайд нарын Зөвлөлийн 50 дугаар хурлын 1 дүгээр зүйлээр Улаанбаатар хотод ус, шавар, цахилгаанаар эмчлэх төв эмнэлгийн газрыг байгуулахаар тогтоожээ.

1942-4-16-нд Сайд нарын Зөвлөлийн 15 дугаар хурлын 6 дугаар зүйлээр хотыг агаарын дайснаас хамгаалах эмнэлгүүдийн ариун цэврийн газрыг байгуулахыг Эрүүлийг хамгаалах яаманд даалгажээ.

1942-4-17-нд Сайд нарын Зөвлөлийн 16 дугаар хурлын 2 дугаар зүйлээр Улаанбаатар хотын төв больницын дэргэдэх донорын цус авах тасгийг өргөтгөн станц болгожээ.

1942-12-29-нд сайд нарын Зөвлөлийн 60 дугаар хурлын 4 дүгээр зүйлээр 1943-1-1-нээс эхлэн Улаанбаатар хотод том хүн, хүүхдийн сүрьеэ өвчний тасаг, ясны ба хоолойн сүрьеэ өвчний тасаг, рентген, лаборатори зэрэг тасгуудтайгаар типеркулёз өвчний диспансериг байгуулахаар тогтоожээ.

1945-3-23-нд сайд нарын Зөвлөлийн 20 дугаар хурлын II дүгээр зүйлээр хотын эмнэлгийн хэлтсийн зохион байгуулалтыг

-Удирдлага

-Байцаагч нарын анги

-Халдварт өвчнийг эсэргүүцэх хэргийг эрхлэх хэлтэс

-Улсын ариун цэврийг шалган байцаах газар бүгд 30 орон тоотойгоор батлагджээ

Эрүүлийг хамгаалах яамны 1951 оны ажлын тайланд Улаанбаатар хотод амбулаториор ирж үзүүлэгчдийн тоо 1949 онд 622800, 11950 онд 275779, 1951 онд 398776 байжээ.

1956-1-20-нд сайд нарын Зөвлөлийн 16 дугаар тогтоолоор Улаанбаатар хотын мэс заслын больницын дэргэд цус сольж, эмчлэх газрыг 1956-2-1-нээс эхлэн байгуулахаар тогтоожээ.

1956-6-8-нд Сайд нарын Зөвлөл, Намын Төв Хорооны 284/167 дугаар тогтоолоор сүрьеэгийн больницын диспансерийг өргөтгөн сүрьеэг эсэргүүцэх улсын төв диспансер болгон байгуулах, Улаанбаатар хотод сүрьеэтэй хүүхэд авах ясли, хүүхдийн сувилалын газар байгуулах, Улаанбаатарын рашаан сувилалд рашаан, шавар эмчилгээний газар байгуулахаар тогтоосон байна.

Сайд нарын Зөвлөлийн 99 дүгээр тогтоолоор 1958-4-15-нд Уушигны өвчний сувилалын газрыг Улаанбаатар хотын Зайсан толгойн аманд барихар тогтоожээ.

1958-9-3-нд сайд нарын Зөвлөлийн 284 дүгээр тогтоолоор Улаанбаатар хотын хороо бүрт хүүхдийн эмнэлэг, үйлчилгэний хэсгийг 1959-9-15-наас эхлэн байгуулахаар тогтоожээ.

1959-7-1-нд Сайд нарын Зөвлөлийн 254 дүгээр тогтоолоор Улаанбаатар хотын сүрьеэгийн болницод мэс заслын тасаг арга маяг, тоо бүртгэлийн тасгийг 1959-7-1-нээс байгуулахаар тогтоосон байна

1959-10-23-нд Сайд нарын Зөвлөлийн 400 дүгээр тогтоолоор улсын ариун цэврийн дүрмийг батлаад хилийн ариун цэврийн шалган байцаах станцыг Улаанбаатар хотын нисэх онгоцны буудалд 1960-1-1-нээс байгуулахаар тогтоожээ.

1960-4-11-нд Сайд нарын Зөвлөл, Намын Төв Хорооны 170/III дүгээр тогтоолоор Халдварт өвчнийг эсэргүүцэх ариун цэврийн улсын станцыг Улаанбаатар хотын станц болгожээ.

Улаанбаатар хотын халдварт өвчнийг эмчлэх сэргийлэх больницын харьяанд бруцеллёзын кабинетыг нээхээр тус тус тогтоожээ.

1963-7-10-нд Сайд нарын Зөвлөлийн 345 дугаар тогтоолоор Улаанбаатар хотын ариун цэвэр, халдвар судлалын станцын хортон устгах товчоог 1963.-8-1-нээс ариутгал ба хортон устгалын салбар болгон өргөтгөж, аж ахуйн тооцоон дээр ажиллуулахаар тогтоожээ.

1968-8-3-нд Сайд нарын Зөвлөлийн 291 дүгээр тогтоол эрүүлийг хамгаалах яамны харьяа улсын нэгдсэн клиникийн 3 дугаар эмнэлэг, ясны сүрьеэ өвчний эмчлэх больницыг 1968 оны 9 дүгээр сарын 1-нээс Улаанбаатар хотын захиргааны мэдэлд шилжүүлжээ.

Улаанбаатар бусад аймаг хотын хүүхдийн зөвлөлгөөн өгөх газарт 1973-1975 онд биеийн тамир, физик эмчилгээний кабинет байгуулахаар тогтоосон байна.

НИЙСЛЭЛ ХОТЫН ЭМНЭЛГИЙН ОР, ИХ ЭМЧИЙН ТОО
/ 1925-1968 ОН /

Он	Ор	Их эмч
1925	14	3
1940	604	17
1948	1035	134
1952	1635	138
1957	2915	211
1960	3175	330
1965	4013	769
1966	4350	827
1968	4376	849
1971 оны календарь		

1972-оны 3, 4 дүгээр сард Сайд нарын Зөвлөлийн 85, 129 дүгээр тогтоолоор халдварт мэнэн өвчний тусгай тасаг 2-ыг байгуулах. Улаанбаатар хотын халдварт өвчнийг анагаах больницод, 24 цагийн ажиллагаатай сэхээн амьдруулах, бригадыг 1972 оны 4 лүгээр сард байгуулахаар тогтоожээ.

1972-6-9-нд сайд нарын Зөвлөлийн 215 дугаар тогтоолоор хуучин үйлдвэрийн хоршооллын эмнэлгийг мэргэжлээс шалтгаалах өвчнийг судлах улсын диспансерт нэгтгэж, үйлдвэрийн эмнэлэг мэргэжлийн өвчний улсын диспансер болгон ажиллуулах.

Улаанбаатар хотын барилгачдын поликлиникиг мөн диспансерт харьяалуулсан байна.

1976-6-25-нд Сайд нарын Зөвлөлийн 141 дүгээр тогтоолоор гоц халдварт өвчнийг эсэргүүцэн судлах газрын хот суурингийн мэргэчтэй тэмцэх групп, Улаанбаатар хотын ариун цэвэр халдвар судлалын станцыг хортон устгалын салбарыг нэгтгэн хортой мэрэгчтэй тэмцэх товчоо болгож, улсын ариун цэвэр, халдвар судлалын байцаан шалгах газрын харьяанд аж ахуйн тооцооны үндсэн дээр ажиллуулахаар тогтоожээ.

1977-9-23-нд Сайд нарын Зөвлөлийн 278 дугаар тогтоолоор арьс өнгөний өвчнийг эсэргүүцэх улсын болон Улаанбаатар хотын диспансерийг арьс өнгөний нэгдсэн больництэй нэгтгэн арьс өнгөний эмгэг судлалын нэгдсэн төв болгон тус тус зохион байгуулсан байна.

1977-9-22-нд Сайд нарын Зөвлөлийн 278 дугаар тогтоолоор Улаанбаатар хотын районуудын арьс өнгөний болон сүрьеэгийн кабинетуудыг диспансер болгон районуудын нэгдсэн эмнэлэгт харьяалуулжээ.

